



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 422

Улаанбаатар хот

“Чоно финанс ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн төлбөрийн баталгаа гаргах болон хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгох тухай



Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Чоно финанс ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн төлбөрийн баталгаа гаргах, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгосугай.

2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, холбогдох өөрчлөлтийн тэмдэглэгээг тусгай зөвшөөрлийн болон Улсын бүртгэлийн гэрчилгээнд хийлгэж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэхийг “Чоно финанс ББСБ” ХХК /Л.Нямсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, холбогдох өөрчлөлтийг Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДЭД ДАРГА

Э.БАТБОЛД